



БАТЛАВ.



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 03

Өлгий хот

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д -д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр гаргасан 41 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2022 оны 05 дугаар сарын 03-ний өдрийн А/03 дугаартай олгосон Ус ашиглуулах зөвшөөрлийг тус тус үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Хар нуур –Ховд голын сав газрын захиргааны Газар зүйн мэдээллийн систем усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн Солтыкей овогтой Зейнелхан.

Ус ашиглагчийг төлөөлж: “ЭС ЖИ ГРУПП” ХХКомпани Улаанбаатар хот, Хан-Уул дүрэг, 15-р хороо, Махатма Ганди гудамж, ЭМ Эс Эн Бьюлдинг, 801 тоот, 901008070 улсын бүртгэл, 2621169 регистрийн дугаартай “ЭС ЖИ ГРУПП” ХХКомпаний уурхайн дарга Д.Жадамба нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 Ус ашиглах зориулалт: Алтны үндсэн ордыг далд аргаар олборлох, уусган баяжуулах

2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1. унд-ахуйд 27,9 м<sup>3</sup>/хоног

2.2.2. үйлдвэрлэлт 300 м<sup>3</sup>/хоног

2.2.3. үйлчилгээ, м<sup>3</sup>/хоног.....

2.2.4. эмчилгээ, сувилгаа, хүн/хоног

2.3. Усны чанар, найрлага

2.4. Усны эх үүсвэрийн: Шүүрлийн ус

Байршил:

Солбицол Х..... Ү..... Z.

Барилга байгууламж.....

Тоног төхөөрөмжийн нэр, марк.....

Хүчин чадал.....

2.5.Хаягдал усны:

Хэмжээ-**54523,25м<sup>3</sup>/жил**

Стандартын шаардлага.....

Хаях цэгийн байршил.....

Солбицол Х..... Ү..... Z

2.10.Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

- Шавхан зайлуулах усны нөөц ашигласны төлбөр: **34 162 299,4** /Гучийн дөрвөн сая нэг зуун жаран хоёр мянга хоёр зуун ерөн есөн төгрөг/

/ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/

#### **Гурав. Талуудын эрх, үүрэг**

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### **Дөрөв. Бусад**

- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3.Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4.Уурхайн үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгах.
- 4.5.Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.6.Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
  - 4.6.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
  - 4.6.2.аль нэг тал татан буугдсан бол

4.7.Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:**

- 2022 оны Хаягдал усны дүгнэлтийн 5 дугаар сард багтан гаргуулах.
- Усны тухай хуулийн 30.6-д заасны дагуу Ховд голын эрэг, голдирлыг үл хөндөх, тос масло асгарах, голын эргийн хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх.
- Усны тухай хуулийн 30.1.2 дахь заалтын дагуу ус ашиглалт хариуцсан усны менежертэй байх
- Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримтыг 2022 оны 12 дугаар сарын 01-ны дотор Хар нуур-Ховд голын сав газрын захиргаанд ирүүлэх
- Усны нөөц ашигласны төлбөр болох **34 162 299,4** төгрөгийг төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу 2022 оны 6 дугаар сард багтаан Баян-Өлгий аймгийн төсөвт төвлөрүүлэх.
- 2022 оны усны нөөц ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.14 дүгээр заалтын дагуу хариуцлага оногдохыг анхаарах.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Хар нуур-Ховд голын С/Захиргааны мэргэжилтэн  
С.Зейнелхан / / Өлгий сум Харилцах  
утас: 99410555

Ус ашиглагчийг төлөөлж:

"ЭС ЖИ ГРУПП" ХХК компанийн уурхайн дарга  
Д.Жадамба / / Цэнгэл сум, 7-р баг Харилцах  
утас: 99377484





ХАР НУУР-ХОВД ГОЛЫН  
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар

А/09

Ховд

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 заалт, Усны тухай хуулийн 28 дүгээр зүйлийн 28.6 дахь заалт болон Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 41 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг дахь "Цагаан овоот уул" төслийг хэрэгжүүлэгч "ЭС ЖИ ГРУПП"ХХКомпанид 2022 оны уурхайн ажилд шаардагдах 64915,25м<sup>3</sup> шүүрлийн усыг нэг жилийн хугацаагаар ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Усны тухай хуулийн 28,6 дахь заалтыг үндэслэн "Эс Жи Групп" ХХКомпанитай ус ашиглуулах гэрээ байгуулж, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж, ус ашиглуулах гэрээг дүгнэж ажиллахыг Газар зүйн мэдээллийн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн С.Зейнелханд даалгасугай.

3. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1, 30.6 дахь заалтуудын дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, 2022 оны 5 сард багтан хаягдал усны дүгнэлт гаргуулах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ тайланг 2022 оны 12 сарын 01-ний дотор багтаан ирүүлэхийг "ЭС ЖИ ГРУПП"ХХКомпаний гүйцэтгэх захирал /Б.Содномпил/-д үүрэг болгосугай.

